



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2025/127/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:

[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Архангай аймаг

2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 7033-3141

Цахим хаяг: [Baigalmaat@audit.gov.mn](mailto:Baigalmaat@audit.gov.mn)

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: [Nerquibaatar@audit.gov.mn](mailto:Nerquibaatar@audit.gov.mn)

Аудитор С.Оргил

Утас: 77665858

Цахим хаяг: [Shinjenmagadlahui.ezsh.audit@gmail.com](mailto:Shinjenmagadlahui.ezsh.audit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.02.24 № 52

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН  
СУМЫН ХҮҮХДИЙН 2 ДУГААР  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
С.АЛТАНЧИМЭГ ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 2-р цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Аудитын гол асуудал

Тус байгууллага нь сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрийн хүрээнд нийт 10 арга хэмжээнд төсвөөс 1,134,753.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэл 87.7 хувь буюу 995,782.8 мянган төгрөгийг зарцуулж, 138,970.8 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

#### Бусад асуудлын хэсэг

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн 2-р цэцэрлэг нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 үндсэн зорилтын хүрээнд 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 94.0 хувьтай байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	181,146,905.11	266,114,986.19
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	100,327,664.59	138,970,929.47
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	100,327,664.59	138,970,929.47
3121	Төгрөг	100,327,664.59	138,970,929.47
31211	Төрийн сангийн харилцах	100,327,664.59	138,970,929.47
35	БАРАА МАТЕРИАЛ	80,819,240.52	127,144,056.72
354	Хангамжийн материал	80,819,240.52	127,144,056.72
3542	Аж ахуйн материал	73,086,556.52	98,539,822.72
3545	Барилгын засварын материал	7,732,684.00	28,604,234.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,236,600,288.77	2,269,433,974.53
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,236,600,288.77	2,269,433,974.53
392	Биет хөрөнгө	2,174,820,288.77	2,207,653,974.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,168,307,453.30	2,168,307,453.30
39202	Хуримтлагдсан элэгдэл	-106,096,360.96	-130,052,764.84
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	52,988,313.50	73,160,484.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	-26,786,882.48	-18,620,100.44
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	94,186,149.30	126,051,223.76
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,190,287.57	-13,830,892.10
39214	Бусад үндсэн хөрөнгө		1,100,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		-38,333.33
39217	Ном	1,411,903.68	1,576,903.68
393	Биет бус хөрөнгө	61,780,000.00	61,780,000.00
39301	Програм хангамж	1,237,500.00	1,237,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,237,500.00	-1,237,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	61,780,000.00	61,780,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,417,747,193.88	2,535,548,960.72
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		1,393,670.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		1,393,670.00
413	Өглөг		1,393,670.00
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг		1,093,670.00
4136	Бусад өглөг		300,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг		300,000.00
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,417,747,193.88	2,534,155,290.72
51	Засгийн газрын хувь оролцоо	2,417,747,193.88	2,534,155,290.72
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	171,582,670.00	171,582,670.00
51101	Өмч: - төрийн	171,582,670.00	171,582,670.00
512	Хуримтлагдсан үр дүн	2,165,232,741.72	2,281,640,838.56
5121	Өмнөх үеийн үр дүн	2,165,232,741.72	2,165,232,741.72
5122	Тайлант үеийн үр дүн		116,408,096.84
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	80,931,782.16	80,931,782.16
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,417,747,193.88	2,535,548,960.72

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,928,711,085.00	1,112,112,944.46
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,117,763,285.00	115,370,844.46
120	Нийтлэг татварын бус орлого	2,117,763,285.00	115,370,844.46
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	140,000.00	37,684,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	140,000.00	37,684,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	2,116,215,914.00	65,057,844.46
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	1,407,371.00	12,629,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	810,947,800.00	996,742,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	722,376,300.00	874,942,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	722,376,300.00	874,942,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	88,571,500.00	121,800,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	88,571,500.00	121,800,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	738,321,436.03	995,704,847.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	738,321,436.03	995,704,847.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	721,242,325.03	995,704,847.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	457,036,897.21	636,874,098.60
210101	Үндсэн цалин	339,971,651.21	454,052,342.32
210102	Нэмэгдэл	105,143,179.00	161,991,103.23
210104	Урамшуулал	11,922,067.00	20,790,012.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,225,761.11	79,110,534.07
210201	Тэтгэврийн даатгал	36,748,067.39	54,592,199.05
210202	Тэтгэмжийн даатгал	4,554,281.52	6,381,547.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,682,475.16	3,154,438.90
210204	Ажилгүйдлийн даатгал	866,656.89	2,977,158.72
210205	Эрүүл мэндийн даатгал	8,374,280.15	12,005,189.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77,546,589.00	100,233,500.00
210301	Гэрэл, цахилгаан	7,467,936.00	12,253,386.01
210302	Түлш, халаалт	58,370,548.00	74,930,987.28
210303	Цэвэр, бохир ус	11,708,105.00	13,049,126.71
2104	Хангамж, бараа материалын зардал	9,686,168.20	9,852,413.80
210408	Бараа материал акталсны зардал	9,686,168.20	9,852,413.80
2105	Нормативт зардал	76,852,000.00	91,250,113.00
210502	Хоол, хүнс	76,852,000.00	91,250,113.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,321,000.00	2,587,450.00
210604	Урсгал засвар	4,321,000.00	2,587,450.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,031,760.00	1,024,935.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,031,760.00	1,024,935.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,542,149.51	74,812,443.70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,864,624.00	34,446,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,376,000.00	7,735,185.00

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26,301,525.51	32,631,158.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,079,111.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,604,200.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,604,200.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,474,911.00	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,474,911.00	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,190,389,648.97	116,408,096.84
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	49,000.00	
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	49,000.00	
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-49,000.00	
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,190,340,648.97	116,408,096.84

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	811,087,800.00	1,034,426,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	140,000.00	37,684,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	140,000.00	37,684,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	140,000.00	37,684,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	140,000.00	37,684,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	810,947,800.00	996,742,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	722,376,300.00	874,942,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	722,376,300.00	874,942,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	88,571,500.00	121,800,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	88,571,500.00	121,800,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	709,368,458.32	995,375,835.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	709,368,458.32	995,375,835.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	692,289,347.32	995,375,835.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	455,133,382.04	636,833,458.05
210101	Үндсэн цалин	330,044,390.04	454,052,342.32
210102	Нэмэгдэл	112,357,442.00	161,991,103.23
210104	Урамшуулал	12,731,550.00	20,790,012.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,129,276.28	79,110,534.07
210201	Тэтгэврийн даатгал	38,349,306.73	54,592,199.05
210202	Тэтгэмжийн даатгал	4,675,020.87	6,381,547.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,610,212.50	3,154,438.90
210204	Ажилгүйдлийн даатгал	863,311.47	2,977,158.72
210205	Эрүүл мэндийн даатгал	8,631,424.71	12,005,189.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77,096,589.00	100,233,500.00
210301	Гэрэл, цахилгаан	7,467,936.00	12,253,386.01
210302	Түлш, халаалт	57,020,548.00	74,930,987.28
210303	Цэвэр, бохир ус	12,608,105.00	13,049,126.71
2105	Нормативт зардал	76,852,000.00	90,156,443.00

**Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 2 дугаар цэцэрлэгийн 2024 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

210502	Хоол, хүнс	76,852,000.00	90,156,443.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,000,000.00	21,566,500.00
210604	Урсгал засвар	7,000,000.00	21,566,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,292,700.00	2,865,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,292,700.00	2,865,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,785,400.00	64,610,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,907,200.00	56,036,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,878,200.00	8,573,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,079,111.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,604,200.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,604,200.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,474,911.00	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,474,911.00	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	101,719,341.68	39,050,264.88
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	6,841,900.00	407,000.00
	Дотоод эх үүсвэрээр	6,841,900.00	407,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,841,900.00	407,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-6,841,900.00	-407,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	94,877,441.68	38,643,264.88
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		100,327,664.59
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		138,970,929.47

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			2,165,232,741.72	2,417,747,193.88
9	Тайлант үеийн үр дүн	-	-	116,408,096.84	116,408,096.84
10	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл			2,281,640,838.56	2,534,155,290.72

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,134,753,700.00	995,782,835.12	138,970,864.88	87.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,134,753,700.00	995,782,835.12	138,970,864.88	87.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,134,753,700.00	995,782,835.12	138,970,864.88	87.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	753,214,900.00	636,833,458.05	116,381,441.95	84.55
210101	Үндсэн цалин	549,776,000.00	454,052,342.32	95,723,657.68	82.59
210102	Нэмэгдэл	195,634,600.00	161,991,103.23	33,643,496.77	82.79
210104	Урамшуулал	7,804,300.00	20,790,012.50	-12,985,712.50	266.39
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,058,200.00	79,110,534.07	7,947,665.93	90.87
210201	Тэтгэврийн даатгал	59,201,400.00	54,592,199.05	4,609,200.95	92.21
210202	Тэтгэмжийн даатгал	6,962,900.00	6,381,547.56	581,352.44	91.65
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,482,200.00	3,154,438.90	327,761.10	90.59
210204	Ажилгүйдлийн даатгал	3,482,200.00	2,977,158.72	505,041.28	85.5
210205	Эрүүл мэндийн даатгал	13,929,500.00	12,005,189.84	1,924,310.16	86.19
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	100,233,500.00	100,233,500.00		100
210301	Гэрэл, цахилгаан	12,588,800.00	12,253,386.01	335,413.99	97.34
210302	Түлш, халаалт	72,812,200.00	74,930,987.28	-2,118,787.28	102.91
210303	Цэвэр, бохир ус	14,832,500.00	13,049,126.71	1,783,373.29	87.98
2104	Хангамж, бараа материалын зардал				
2105	Нормативт зардал	102,145,000.00	90,156,443.00	11,988,557.00	88.26
210502	Хоол, хүнс	102,145,000.00	90,156,443.00	11,988,557.00	88.26
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,566,500.00	21,566,500.00		100
210604	Урсгал засвар	21,566,500.00	21,566,500.00		100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,865,300.00	2,865,300.00		100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,865,300.00	2,865,300.00		100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	67,670,300.00	65,017,100.00	2,653,200.00	96.08
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	58,932,100.00	56,278,900.00	2,653,200.00	95.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,738,200.00	8,738,200.00		100
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,134,753,700.00	1,034,426,100.00	100,327,600.00	91.16
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	874,942,100.00	874,942,100.00		100

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 2 дугаар цэцэрлэгийн 2024 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

131001	Улсын төсвөөс санхүүжих	874,942,100.00	874,942,100.00		100
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	121,800,000.00	121,800,000.00		100
132001	Орон нутгийн төсвөөс	121,800,000.00	121,800,000.00		100
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	138,011,600.00	37,684,000.00	100,327,600.00	27.3
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	37,684,000.00	37,684,000.00		100
120004 3	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	100,327,600.00		100,327,600.00	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		100,327,664.59	100,327,664.59	-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		138,970,929.47	138,970,929.47	-
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО		1		100
3	Төсвийн байгууллага		1		100
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО		30		100
6	Удирдах ажилтан		1		100
7	Гүйцэтгэх ажилтан		19		100
8	Үйлчлэх ажилтан		10		100
14	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА		1		100
15	Төрийн өмчит СӨБ байгууллага		240		100
24	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ		30		100
28	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)		18		100
32	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)		1		100
33	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)		11		100

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар явцад 2,456.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг Аж ахуйн материалын дансанд бүртгэсэн бүртгэлийг залруулан ажилласан болно.

Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 2 зөрчил<sup>1</sup> илэрсэн бөгөөд зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ. Аудитаар илэрсэн зөрчил нь материаллаг бус байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 3.1. Албан шаардлага

5.1.1 Харилцагч байгууллагуудтай тухай бүр авлага, өглөгийн тооцоо нийлж баталгаажуулаагүйгээс оны эцэст 1,393.6 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй гарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 -т 'эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх үр, дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах' гэж заасныг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Өр төлбөрийг барагдуулах албан шаардлага хүргүүлээ.

#### 3.2. Зөвлөмж

Хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон ахуйн хэрэгслийн орлого, зардлын бүртгэл тайлантай холбоотой.

**Илрүүлэлт:** Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон эрүүл ахуйн хэрэгслийг Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн А/273 дугаар тушаалын хавсралтаар баталсан жагсаалтын дагуу эцэг, эх, асран хамгаалагчдаас хүлээн авсныг нягтлан бодох бүртгэл, тайланд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, 14.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4, 16 дугаар зүйлийн 16.5.7 дахь заалттай нийцэхгүй байна.

**Зөвлөмж:** Аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх, цаашид хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон эрүүл ахуйн хэрэгслийг хүлээн авсан үед бараа материалын зохих дансанд орлогоор, сургалтын үйл ажиллагаанд тавьж олгосон тухай бүр зардлаар бүртгэж бараа материалын тайлан бэлтгэж үр дүнг санхүүгийн тайланд тусгаж, мэдээлэх арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг хүргүүлж байна.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "... албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасан тул зөвлөмжийн төлөвлөгөөг 2025.03.25-ны өдрийн дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлж ажиллана уу.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэхүү зөвлөмжийн төлөвлөгөөг ирүүлээгүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсэгт заасан ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болохыг анхааруулна уу.

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал  
илэрхийлье.*

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа материалын дансанд хөрөнгийг буруу бүртгэсэн	1	2,456.1			1	2,456.1	1	2,456.1				

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өр төлбөртэй	1	1,393.6			1	1,393.6						
Бараа материалтай холбоотой	1	0					1	0				
дүн	2	1393.6			11	1396.6	1	0				